

БАРАА ХУДАЛДАН АВАХ ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

/ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР/

Төслийн нэр: **Органик Хөдөө Аж Ахуйн Түншлэл-II төсөл**

Санхүүжилтийн эх үүсвэр: BMZ, ADRA Germany

Гэрээний дугаар ба нэр: **Хүнсний боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж ханган нийлүүлэх -01**

Хүсэлтийг гаргасан огноо: 2025 оны 01 сарын 20-ны өдөр

Эрхэм Танаа:

1. “Адра” Олон улсын байгууллага (цаашид “Захиалагч” гэх) дараах нэрийн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх үнийн санал танай аж ахуйн нэгжээс ирүүлэхийг үүгээр хүсч байна:

Багц 1: Хүнсний боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж ханган нийлүүлэх -01

Та энэхүү худалдан авах ажиллагааны гэрээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн компанийтай хэрэв хамтран оролцож байгаа бол таны саналаас татгалзана.

Үнийн санал бэлтгэхэд зориулан шаардлагатай техникийн тодорхойлолт болон нийлүүлэх тоо хэмжээний талаарх мэдээллийг хавсаргав. (*Хавсралт 1-ээс техникийн тодорхойлолтыг үзнэ үү*)

2. Та энэхүү хүсэлтийн дагуу тухайн сонгосон **бараануудад** саналаа ирүүлэх ёстой. Үнийн саналыг бараанд хамгийн сайн үнэлэгдсэн үнийг санал болгосон компанид гэрээний эрх олгоно.

3. Та энэхүү тендерт оролцохыг сонирхвол дараах баримт бичгүүдийг Монгол хэл дээр цахимаар ирүүлнэ:

- a. Байгууллагын хүсэлт бүхий албан бичиг,
- b. Байгууллагын гэрчилгээ, танилцуулга,
- c. Сүүлийн 3 жилд (2021, 2022, 2023) санал болгож буй багцын бараа материалтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх ба ингэхдээ тендерт оролцгчийн тухайн нийлүүлсэн барааны гэрээт ажлын үнийн дүн **20,000,000.00** /хорин/ сая төгрөгөөс доошгүй байна. Үүнийг батлах гэрээний хуулбар, гэрээг дүгнэсэн акт болон бусад материалын хамт ирүүлнэ.
- d. Үнийн саналын маягт, гарын үсэг зурж, тамгалж баталгаажуулах ба гараар бөглөхгүй болно (*Хавсралт 2*),
- e. Санал болгосон бараа тус бүрт техникийн хангалттай баримт, каталог, бусад хэвлэмэл материал, гарын авлага эсвэл хамаарал бүхий мэдээлэл, түүнчлэн Монгол улсад борлуулалтын дараах үйлчилгээ үзүүлэх компанийн нэр ба хаяг зэргийг заана.

5. Таны саналыг хүлээн авах эцсийн хугацаа: **2025 оны 02 сарын 03-ны өдрийн 13:00** цаг байх ба procurement@adra.org.mn хаяг руу ирүүлнэ үү.

6. Та дээр дурдсан барааны саналыг байгууллагын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Таны саналын маягт гарын үсэггүй тохиолдолд, саналыг тань үнэлгэнд харгалзахгүй болохыг анхаарна уу.

7. Та саналаа дараах заавар болон гэрээний маягтын дагуу ирүүлнэ. Гэрээнд хавсаргасан нийлүүлэлтийн нөхцөл шаардлага нь гэрээний салшгүй хэсэг болно.

- (i) ҮНЭ: _____ (тоогоор, үсгээр) төгрөгийн үнэ бүхий барааг нийлүүлэх болон хүргэх зардлыг багтаана. Үнийн санал ирүүлэх эцсийн хугацаанд хүчинтэй байгаа Монгол улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж байгаа аливаа татвар, хураамж, шимтгэлийг багтаасан байна. Санал болгосон үнээс гадна, үнэлэгдсэн үнэд Монгол улсад мөрдөж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг тусад нь тодорхой салгаж оруулна.
- (ii) САНАЛЫГ ҮНЭЛЭХ: Техникийн тодорхойлолтыг (Хавсралт 1) үндсэнд нь хангаж буй саналуудын үнийг хооронд нь харьцуулах замаар үнэлнэ. Хэрэв тухайн санал нь том зөрүү агуулсан, эсвэл санал авах хүсэлтэнд заасан нөхцөл, шаардлага, тодорхойлолтын хувьд болзолт нөхцлийг шаардсан бол ийм саналыг үндсэндээ шаардлагад нийцэхгүй гэж үзэж, түүнийг цаашид үнэлгэнд харгалзахгүй. Захиалагч зөвхөн үндсэндээ шаардлагад нийцсэн саналуудыг үнэлж харьцуулна. Захиалагч саналуудыг үнэлэхдээ, тооцооллын алдааг дараах байдлаар залруулна:
- (a) тоогоор болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх;
 - (b) нэгж үнийг тоогоор үргүүлсэнтэй холбоотойгоор нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах; ба
 - (c) нийлүүлэлгэч арифметик залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, түүний саналаас татгалзана.
- (iii) ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГЫН ЭРХ: Гэрээний эрхийг хамгийн сайн үнэлэгдсэн үнийг санал болгосон, техникийн ба санхүүгийн чадварын шаардсан жишгийг хангаж байгаа ханган нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгоно. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь гэрээг албан ёсоор бэлтгэж хэрэгжүүлэх хүртэл гэрээний үүргийг гүйцэтгэнэ. Шалгарсан тендерт оролцогч хавсралтанд байгаа гэрээний маяг болон нийлүүлэлтийн нөхцөл шаардлагад заасны дагуу гэрээнд гарын үсэг зурна.
- (iv) САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА: Таны санал энэхүү санал авах хүсэлтийн 5 дугаар заалтад дурдсаны дагуу санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн туршид хүчинтэй байна.
- (v) Хэрэв та тендерийн хүчинтэй хугацаанд өөрийн саналаа буцааж авах ба/эсвэл гэрээний эрх олгогдсон байхад гэрээний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал таныг хоёр жилийн хугацаанд Адра ОУБ-ын ханган нийлүүлэгчдийн жагсаалтаас Захиалагчийн зүгээс хасах эрхтэй болохыг анхаарна уу.

8. Нэмэлт мэдээллийг дараах хаягаас авах боломжтой:

Харилцах албан тушаалтан: Худалдан авалтын мэргэжилтэн
Цахим шуудан: procurement@adra.org.mn

9. Захиалагч санал ирүүлэх хугацаанаас хойш **30** хоногийн дотор санал нь хүлээн зөвшөөрөгдсэн тендерт оролцогчид зөвшөөрлийн цахим захидалыг илгээж, гэрээний эрх олгосон тухай мэдэгднэ.

10. Адра ОУБ-ын авлигын эсрэг бодлогын дагуу, тендерт оролцогч худалдан авах ажиллагаа болон түүнээс үүдэн гарах гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Хэрэв гэрээний эрх авсан тендерт оролцогч эсвэл аливаа этгээд тендерт өрсөлдөх эсвэл гэрээг хэрэгжүүлэх үед авилгал, запилан мэхлэх, угсэн хуйвалдах эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд оролцсон нь тогтоогдвол Адра ОУБ гэрээний эрх олгох саналаас татгалзаж, үүнд холбогдсон этгээдэд хориг тогтооно.

11. Та цахим шуудангаар энэхүү хүсэлтийг авсан тухай болон үнийн санал ирүүлэх эсэхээ **2025 оны 1-р сарын 25-ний 13:00** цагийн дотор 8-р хэсэгт заасан цахим шуудангаар мэдэгдэнэ үү.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БА ШААРДЛАГА

1. Тогтмол үнэ: Саналын маягтанд заасан үнэ нь тогтмол байх ба гэрээний хэрэгжилтийн явцад түүнд ямар нэгэн залруулга өөрчлөлт үл оруулна.
2. Нийлүүлэх хуваарь: Нийлүүлэлтийг дээрх хуваарийн дагуу, гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс **30** хоногийн дотор хийж дуусгана.
3. Мөрдөх хууль: Гэрээг захиалагчийн улсын хуулийн дагуу хэрэгжүүлнэ.
4. Маргаан шийдвэрлэх: Захиалагч ба нийлүүлэгч нь тэдгээрийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа үл тохиролцол эсвэл маргааныг албан бус, шууд хэлэлцээрээр зөвшилцөн шийдэхийг хичээнэ. Захиалагч ба нийлүүлэгчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд, уг маргааныг захиалагчийн улсын арбитрын хууль дүрмийн заалтын дагуу шийдвэрлэнэ.
5. Барааны нийлүүлэлт ба холбогдох бичиг баримт: Нийлүүлэгч барааг нийлүүлэхдээ дараах баримтуудыг захиалагчид гаргаж өгнө:
 - (i) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж үнэ болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хуулбар;
 - (ii) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; ба
 - (iii) Барааны гарал үүслийн гэрчилгээ (шаардлагатай бол).
6. Шалгалт туршилт: Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Барааны шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг нийлүүлэгч санал болгосны үндсэн дээр зохион байгуулна. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгчийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай баримт бичиг, техникийн баримт бичиг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй бол захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсхүл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй. Энэ зүйлийн аль ч нөхцөл нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
7. Төлбөр: Гэрээний үнийн төлбөрийг дараах нөхцлийн дагуу гүйцэтгэнэ:
 - Гэрээний нөхцлийн дагуу нийлүүлсэн барааг Захиалагчид хүлээлгэн өгсөн болон Захиалагч нь зохих нэхэмжлэх болон бусад дагалдах баримт бичиг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт төлбөрийг **100** хувь шилжүүлнэ.
8. Чанарын баталгаа: Санал болгосон бараа нь захиалагчид нийлүүлсэн өдрөөс хойш 12-с доошгүй сарын, үйлдвэрлэгчийн чанарын баталгаатай байна.
9. Гэмтэл согог: Нийлүүлэгч бүх гэмтэл согогийг захиалагчаас мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор захиалагчаас ямар нэгэн зардал гаргахгүйгээр засварлана. Баталгаат хугацаанд нийлүүлэгчээс гэмтэл согогийг засварлах газрын нэр хаяг:

Газар: _____

Хаяг: _____

10. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл: Хэрэв гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний хүрээнд ажлын гүйцэтгэл удааширсан эсхүл гэрээний үүргийг биелүүлэх явцад аливаа алдаа гарсан тохиолдолд нийлүүлэгч тorgууль эсхүл гэрээг цуцалсан асуудлыг хариуцахгүй.

Энэ зүйлийг тодруулах зорилгоор, “гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл” гэдэг нь нийлүүлэгчийн хяналтаас гадуур, бөгөөд нийлүүлэгчийн алдаа эсхүл хайхрамжгүй байдлаас ангид, ба урьдчилан харах боломжгүй үйл явдлыг хэлнэ. Ийм үйл явдалд дайн, эсвэл хувьсгал, гол түймэр, үер, халдварт өвчин, хорио цээр, ба ачаа тээврийн хориг орж болох бөгөөд энэ нь нийлүүлэгчийн бие даасан чадамжийн хүрээнд түүний үйлдлээр хязгарагдахгүй болно.

Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайж олно.

11. Шаардлагатай техникийн тодорхойлолт: (шаардлагатай бол хавсралтаар гаргаж бэлтгэх)

- (i) Ерөнхий тойм
- (ii) Онцлог нарийн болон техникийн жишиг үзүүлэлтүүд
- (iii) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Нийлүүлэгч дээр дурдсан үзүүлэлтүүдэд нийцэж байгааг үүгээр баталж байна.